Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 349024.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6980.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 525694.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10513.9 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1779841.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 49713.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,120.4 | 48,750.6 | 19,630.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 7,816.4 | 7,816.4 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 29,120.4 | 40,934.2 | 11,813.8 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,701,007.6 | 1,731,090.6 | 30,083.0 |
| Үндсэн хөрөнгө | 3,131,051.1 | 3,279,794.1 | 148,743.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,430,043.5) | (1,548,703.4) | (118,659.9) |
| **Нийт хөрөнгө** | 1,730,128.0 | 1,779,841.2 | 49,713.2 |
| Өр төлбөр | - | 300.0 | 300.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,730,128.0 | 1,779,541.2 | 49,413.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,730,128.0 | 1,779,841.2 | 49,713.2 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Өмнөх онд дансны авлагагүй ба харин тайлант онд ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн 18.4 мянга, шатахуун бэлтгэн нийлүүлэгч “НИК” ХХК-д илүү шилжүүлсэн 208.0 мянга, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй малыг зээлээр борлуулсны авлага 540.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс худалдаж авсан өвс тэжээлийг малчдад зээлээр борлуулсны 7050.0 мянга, нийт 7816.4 мянган төгрөгийн авлага үүссэнийг санхүүгийн тайланд бүртгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 40934.2 мянган төгрөг болж 11813.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансанд Covid-19 цар тахалтай холбоотой 1578.7 мянган төгрөгийн халдвар хамгаалал, ариутгалын хэрэгсэл авч нөөцөлсөн, бусад хангамжийн материалын дансанд өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зорилгоор Засаг даргын нөөц хөрөнгөөс 16225.0 мянган төгрөгийн өвс, тэжээл авч нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3279794.1 мянган төгрөг болж 148743.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11940.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 137852.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 108 дугаар тогтоолоор 1050.0 мянган төгрөгийн ашиглалтгүй программ хангамж акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 128004.4 “Ухаалаг - Баянхонгор” төслийн санхүүжилтээр 4538.1 мянга, “Хавтгай хамгаалах” олон улсын төслийн санхүүжилтээр 4310.4 мянга, урсгал төсвийн худалдан авалтаар 11940.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1779541.2 мянган төгрөг болж 49413.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 49413.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 575107.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 358915.4 мянган төгрөгөөр буюу 38.4 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөвт байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 405817.0 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 43901.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 63526.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан санхүүжилт 16624.4 мянган төгрөгөөр буурсантай тус тус холбоотой байна.

Нийт зардал 525694.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 76549.5 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил урсгал засварын зардал, хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 387915.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 387915.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18784.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 406700.2 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 406700.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 405700.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр 1000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 400050.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1513.0 мянга, нийт 401563.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 383603.9 мянган төгрөгийг зарцуулж 17960.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 383603.9 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 6678.6 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1454.5 байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 3196.9 мянга, хангамж бараа материалын зардлыг 4248.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 651.5 мянга, томилолт зочны зардлыг 2615.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний зардлыг 2014.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1086.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 70106 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 15234.6 мянга, 80106 арга хэмжээ 4905.4 мянга, 80802 арга хэмжээ 800.0 мянга, 81102 арга хэмжээ 159.3 мянга, 82212 арга хэмжээ 1997.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэлийн тайлан /*Хөтөлбөр, арга хэмжээгээр*/ төгрөгөөр

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 70106 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 318,498,500.00 | 303,263,872.00 | 15,234,628.00 | 95.22 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 318,498,500.00 | 303,263,872.00 | 15,234,628.00 | 95.22 |
| Бараа, үйлчилгээний зардал | 318,498,500.00 | 303,263,872.00 | 15,234,628.00 | 95.22 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 188,870,500.00 | 182,441,312.00 | 6,429,188.00 | 96.60 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,696,700.00 | 23,327,300.00 | 369,400.00 | 98.44 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 47,074,200.00 | 44,246,485.00 | 2,827,715.00 | 93.99 |
| Хангамж, бараа материалын зардал | 25,705,300.00 | 23,541,875.00 | 2,163,425.00 | 91.58 |
| Эд хогшил худалдан авах | 15,800,000.00 | 15,705,000.00 | 95,000.00 | 99.40 |
| Томилолт, зочны зардал | 7,293,600.00 | 4,875,000.00 | 2,418,600.00 | 66.84 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 5,858,200.00 | 5,854,200.00 | 4,000.00 | 99.93 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,200,000.00 | 3,272,700.00 | 927,300.00 | 77.92 |
| АРГА ХЭМЖЭЭ 80106 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 55,970,700.00 | 51,065,267.00 | 4,905,433.00 | 91.24 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 55,970,700.00 | 51,065,267.00 | 4,905,433.00 | 91.24 |
| Бараа, үйлчилгээний зардал | 55,570,700.00 | 51,015,267.00 | 4,555,433.00 | 91.80 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 40,435,200.00 | 40,185,757.00 | 249,443.00 | 99.38 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,459,200.00 | 4,374,142.00 | 1,085,058.00 | 80.12 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 694,800.00 | 325,568.00 | 369,232.00 | 46.86 |
| Хангамж, бараа материалын зардал | 4,404,400.00 | 2,319,000.00 | 2,085,400.00 | 52.65 |
| Эд хогшил худалдан авах | 3,756,500.00 | 3,200,000.00 | 556,500.00 | 85.19 |
| Томилолт, зочны зардал | 762,600.00 | 566,000.00 | 196,600.00 | 74.22 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 58,000.00 | 44,800.00 | 13,200.00 | 77.24 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 400,000.00 | 50,000.00 | 350,000.00 | 12.50 |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,000,000.00 | 200,000.00 | 800,000.00 | 20.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,000,000.00 | 200,000.00 | 800,000.00 | 20.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,000,000.00 | 200,000.00 | 800,000.00 | 20.00 |
| АРГА ХЭМЖЭЭ 81102 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 21,000,000.00 | 20,840,725.00 | 159,275.00 | 99.24 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 21,000,000.00 | 20,840,725.00 | 159,275.00 | 99.24 |
| Бараа, үйлчилгээний зардал | 21,000,000.00 | 20,840,725.00 | 159,275.00 | 99.24 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 21,000,000.00 | 20,840,725.00 | 159,275.00 | 99.24 |

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 70106 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 81701 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,231,000.00 | 4,231,000.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 4,231,000.00 | 4,231,000.00 | - | 100.00 |
| Бараа, үйлчилгээний зардал | 4,231,000.00 | 4,231,000.00 | - | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,231,000.00 | 4,231,000.00 | - | 100.00 |
| АРГА ХЭМЖЭЭ 82212 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,000,000.00 | 4,003,000.00 | 1,997,000.00 | 66.72 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 6,000,000.00 | 4,003,000.00 | 1,997,000.00 | 66.72 |
| Бараа, үйлчилгээний зардал | 6,000,000.00 | 4,003,000.00 | 1,997,000.00 | 66.72 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 6,000,000.00 | 4,003,000.00 | 1,997,000.00 | 66.72 |

*Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүснэгт 3. нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа төгрөгөөр

| № | Орлогы төрөл | ЗАРДЛЫН ДҮН | Зардлын төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Мал тооллогын зардал | Хамтарсан багийн зардал | Урсгал засвар | шагнал урамшуулал | Төвлөрүүлсэн |
| 1 | Түрээсийн орлого | 50,000.00 | | | | | 50,000.00 |
| 2 | Статистикийн хэлтсээс | 1,275,985.00 | 648,857.00 | | | | 627,128.00 |
| 3 | Сумын аваргын шагнал | 9,970,000.00 | | | 1,350,000.00 | 4,570,000.00 | 4,050,000.00 |
| 4 | Гэр бүх хөгжлийн газар | 1,000,000.00 | | 640,000.00 | | | 360,000.00 |
| 5 | Тендерийн хураамж | 105,000.00 | | | | | 105,000.00 |
| 6 | Ус ашигласаны төлбөр | 504,000.00 | | | | | 504,000.00 |
| 7 | Малжуулах | 12,401,690.00 | | | | | 12,401,690.00 |
| 8 | нөхөн сэргээлтийн төлбөр | 1,000,000.00 | | | | | 1,000,000.00 |
| | НИЙТ ДҮН | 26,306,675.00 | 648,857.00 | 648,857.00 | 1,350,000.00 | 4,570,000.00 | 19,097,818.00 |

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс тухай бүр оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 15978.3 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 4. Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 11 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 33 | 3 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 92 | 4 | |
| | Нийт | 27 | 151 | 144 | 7 | 2 |

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 194.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг биелүүлсэн бол, 31000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Аудитаар өгсөн 1350.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 194.0 | 1 | 194.0 | | | |
| Албан шаардлага | 1 | 31000.0 | 0 | 0.0 | 1 | 31000.0 | 100.0 |
| Зөвлөмж | 3 | 1350.0 | 3 | 1350.0 | | | |
| Нийт дүн | 5 | 32544.0 | 4 | 1544.0 | | | |

Хэрэгжүүлээгүй 31000.0 мянган төгрөгийн албан шаардлага нь "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан Монгол улсад орж ирсэн гаалийн бичигтэй болovч хог тээврийн автомашин нь ЗДТГ-ын эзэмшилд бүртгэгдээгүй Ганбаяр гэсэн иргэний нэр дээр бүртгэлтэй байна" гэсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага ба Баян-Өндөр сумын Засаг даргын 2020.12.28-ы өдрийн 119 тоот албан бичгээр Өвөрхангай аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан ба тус асуудлыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2021.02.05-ны өдрийн 1/31 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн, одоогоор асуудал шийдвэрлэгдээгүй байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3535.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2508.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 60.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 967.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Баян-Өндөр сумын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлөөс 2020 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хилийн 0166 дугаар ангийн хилийн манаанд ашиглах зориулалтаар тавилга, эд хогшил худалдан авах зардлаас 2000.0 мянган төгрөгийн өртөгтэй мотоцикл худалдан авсныг үндсэн хөрөнгөндөө бүртгэж аваагүй байна.
   **Шийдвэрлэсэн нь**: Санхүүгийн тайланд 2000.0 мянган төгрөгийн хөрөнгийн үндсэн хөрөнгөд бүртгэж залруулга хийв.
2. Тайлант хугацаанд түлш шатахуун бэлтгэн нийлүүлэгч НИК ХХК-аас 10893.9 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан ч тус компанид 11101.9 мянган төгрөг буюу 208.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн ч авлагаар тусгаагүй байна.
   **Шийдвэрлэсэн нь**: Санхүүгийн тайланд 208.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэж залруулга хийв.
3. Тайлант хугацаанд түлш шатахуун бэлтгэн нийлүүлэгч иргэн М.Жаргалсайханаас 10835.3 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан ч 300.0 мянган төгрөгийн шатахууныг орлогоор бүртгээгүйгээс тус компанид 10535.3 мянган төгрөг буюу 300.0 мянган төгрөг дутуу шилжүүлсэн ба санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.
   **Шийдвэрлэсэн нь**: Санхүүгийн тайланд 300.0 мянган төгрөгийн өглөгийг тусгаж залруулга хийв.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 60.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тус байгууллагын тохижилт үйлчилгээний ажилтан А.Амартүвшиний урамшуулалт цалинг 2020 оны 10, 11 дүгээр саруудад тус бүр 30000 төгрөгөөр илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3. ""хөдөлмөрийн гэрээ" гэж нэг талаас

ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог;", А.Амартүвшинтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний 1.1 дэх "...Урамшуулалт цалин 300000 төгрөг..." гэсэн заалттай тус тус нийцэхгүй, "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**:Төлбөрийн акт тогтоож төлүүлэхээр шийдвэрлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 967.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. *Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал***

1.1. *Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, , батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 15978.3 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн.

*1.2. Эрсдэл:* Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх.

*1.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хугацаанд нь мэдээлж хуулийг хэрэгжүүлж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:* Тайлант хугацаанд тээвэр шатахууны зардлаас 582.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын үнэ шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх” зарчим, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

*2.2. Эрсдэл*: Төсвийн зардлын бүлэгт хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зардлыг үнэн зөв бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж, бичиг хэргийн зардлыг өөр зардлаас зарцуулж гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***3. Балансын данстай холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:* Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1175.0 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэйгээс 385.0 мянган төгрөгийн үнэ бүхий төрийн сангийн программ нь ашиглалтгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь "эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохирохгүй болсон ... бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*3.2. Эрсдэл*: Ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасаагүй байх.

*3.3. Өгсөн зөвлөмж:* Дансанд бүртгэлтэй төрийн сангийн программыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| **Огноо** | **Аудитын нэр:** | Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | **Аудитын код:** |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/34/СТА-ТШ3 |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Баян-Өндөр сумын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлөөс 2020 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хилийн 0166 дугаар ангид хилийн манааны уналгын 2000.0 мянган төгрөгийн өртөгтэй мотоцикл өгсөн байна. Үүнийг үндсэн хөрөнгөндөө бүртгэж аваагүй байна. | 2,000.0 | Санхүүгийн тайланд залруулах | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 2 | Тайлант хугацаанд түлш шатахуун бэлтгэн нийлүүлэгч НИК ХХК-аас 10893.9 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан ч тус компанид 11101.9 мянган төгрөг буюу 208.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн ч авлагаар тусгаагүй. | 208.0 | Санхүүгийн тайланд залруулах | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 3 | Тайлант хугацаанд түлш шатахуун бэлтгэн нийлүүлэгч иргэн М.Жаргалсайханаас 10835.3 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан ч 300.0 мянган төгрөгийн шатахууныг орлогоор бүртгээгүйгээс тус компанид 10535.3 мянган төгрөг буюу 300.0 мянган төгрөг дутуу шилжүүлсэн ба санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй. | 300.0 | Санхүүгийн тайланд залруулах | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 4 | Тус байгууллагын тохижилт үйлчилгээний ажилтан А.Амартүвшиний урамшуулалт цалинг 2020 оны 10, 11 дүгээр саруудад тус бүр 30000 төгрөгөөр илүү олгосон. | 60.0 | Төлбөрийн акт тогтоох | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 5 | Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1175.0 мянган төгрөгийн программ хангамж бүртгэлтэйгээс 385.0 мянган төгрөгийн үнэ бүхий төрийн сангийн программ нь ашиглалтгүй байна. | 385.0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 6 | Тайлант хугацаанд тээвэр шатахууны зардлаас 582.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын үнэ шилжүүлсэн. | 582.0 | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| 7 | Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, , батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 15978.3 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | - | Зөвлөмж өгөх | Дарга, нягтлан бодогч | Э.Амгаланбаяр , Т.Уянга |
| | **ДҮН** | **3535.0** | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР — Ж.ӨСӨХБАЯР 2021.02.10

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ 2021.02.10

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ 2021.02.10